



ДУНДГОВЬ АЙМАГ
ГОВЬ-УГТААЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 03 сарын 30 өдөр

Дугаар А/19

Хажуу шинэ үс

Шууд гэрээ байгуулах эрх олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ, бараа худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.4, 46.1.6, Орон нутгийн хөгжлийн сангийн ажлын хэсгийн 2023 оны 03 дугаар сарын 30-ний өдрийн 01 дүгээр хуралдааны тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар Өрнөлт багт худаг гаргах 18,000,000.00 (Арван найман сая) төгрөгийн үнийн санал ирүүлсэн О.Хүүхэнбаатар захиралтай "Эхний Эхэн" ХХК-тай шууд гэрээ байгуулах эрхийг Засаг даргын Тамгын газрын дарга (Н.Өлзийтогтох)-д олгосугай.

2. Өрнөлт багт худаг гаргах ажлыг захиалагчийн гаргасан саналд үндэслэн чанар сайтай хийж гүйцэтгэхийг "Эхний Эхэн" ХХК-ийн захирал (О.Хүүхэнбаатар)-т даалгасугай.

3. О.Хүүхэнбаатартай ажил гүйцэтгэх гэрээ байгуулж, ажлын явцад гүйцэтгэлийн хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Н.Өлзийтогтох), Санхүү албаны дарга (Н.Ганбат) нарт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Т.АРИУНАА